

Ерөнхий мэргэжлийн эмч

Тестийн зөв хариулт-1

1-E, 2-E, 3-E, 4-E, 5-E, 6-E, 7-E, 8-A, 9-E, 10-E, 11-E, 12-A, 13-E, 14-C, 15-E, 16-A, 17-A, 18-A, 19-A, 20-E, 21-E, 22-E, 23-B, 24-D, 25-E, 26-E, 27-A, 28-D, 29-B, 30-A, 31-A, 32-A, 33-C, 34-B, 35-C, 36-C, 37-D, 38-B, 39-C, 40-D, 41-C, 42-A, 43-C, 44-C, 45-A, 46-B, 47-E, 48-E, 49-E, 50-E, 51-C, 52-E, 53-C, 54-D, 55-A, 56-A, 57-B, 58-A, 59-A, 60-A, 61-C, 62-A, 63-A, 64-A, 65-B, 66-A, 67-A, 68-A, 69-A, 70-B, 71-A, 72-A, 73-E, 74-E, 75-A, 76-C, 77-D, 78-E, 79-D, 80-E, 81-D, 82-D, 83-B, 84-A, 85-D, 86-D, 87-B, 88-D, 89-A, 90-B, 91-B, 92-E, 93-B, 94-E, 95-E, 96-A, 97-B, 98-C, 99-A, 100-C,

Тестийн түлхүүр

1. Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх) Энэ хэлбэрийн сорил нь А, В, С, D, E

гэсэн дугаартай бөгөөд Зөвхөн 1 зөв хариуг сонгоно.

2. Олон сонголттой тест (Хэдэн ч хариулт зөв байж болох)

1, 2, 3 дугаар хариултууд зөв бол (A.)

1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол (B.)

2 ба 4 дүгээр хариултууд зөв бол (C.)

Зөвхөн 4-р хариулт зөв бол (D.)

Бүх хариулт зөв бол (E.)

3. Шалтгаан хамаарлын тест (Заагдсан тестүүдийн үнэн зөв хийгээд тэдгээрийн шалтгаан хамаарлыг тодорхойлно.)

Зөв, Зөв, Зөв (A.)

Зөв, Зөв, Буруу (B.)

Зөв, Буруу, Буруу (C.)

Буруу, Зөв, Буруу (D.)

Буруу, Буруу, Буруу (E.)

1./ Хүүхэд амьсгалын эрхтэний өвчнүүдээр өвчлөмтгий байдгийн учир нь дараахтай шууд ба дам холбоотой:

1. Хүүхдийн амьсгалын эрхтэн тогтолцооны бүтэц үйлийн онцлог*

2. Гадаад орчинд дасан зохицох чадвар*

3. Өвчин эсэргүүцэх чадвар*

4. Суурь эмгэгүүд*

5. Амьдарч буй орчин*

/2./ Хүүхэд нусгайрах шалтгааныг зөв сонгоно уу:

1. Орчны халуун хүйтний хэм эрс тэс хэлбэлзэх*

2. Агаар тоосжих, бохирдох, хуурайших*

3. Нян вирус*

4. Амьтан ургамлын гаралтай тоосонцор*

5. Эм ба хүнсний бүтээгдхүүн*

/3./ Нусгайрах үед илрэх бүтцийн эмгэг өөрчлөлтүүдийг нэрлэнэ үү:

1. Хамрын салст хөөж хавагнах*

2. Хамрын судсууд өргөсөж цус хурах, шүүрэх*

3. Олон эст бүрхүүл эсүүд ховхорч, цөөрөх*

4. Намираа эсийн сормосон шилбүүрүүд арилах*

5. Цагаан эсүүд бөөгнөрч, хурах*

/4./ Хөхүүл насны хүүхэд нусгайрах үед илрэх эмнэлзүйн шинжүүдийг сонгоно уу:

1. Хүүхэд уйлагнаж тавгүйрхэх
2. Хамар битүүрэх
3. Хөхөө хөхөж чадахгүй
4. Тайван унтахгүй, уцаартай
5. Хамраас нус гоожих, найтаах

/5./ Ахлах насны хүүхэд нусгайрах үед илрэх эмнэлзүйн шинжүүдийг сонгоно уу

1. Залхуу хүрч, бие зарайх
2. Толгой өвдөх
3. Найтааж нусгайрах
4. Хамар битүүрч, амт үнэр ялгахгүй болох
5. Зарим үед чихээр хатгаж, шуугих

/6./ Хүүхэд нусгайрах үед эмчлэх аргыг зөв сонгоно уу:

1. Хамрыг тогтмол цэвэрлэх
2. 0.9%-ийн физиологийн уусмал хамарт 1-2 дулаар ойр ойрхон дусаах
3. Хооллохын өмнө хамрын битүүрлийг арилгах
4. Хамрыг хэт ягаан туяагаар өдөрт 1 удаа 4-5 мин, 5-7 удаа шарах
5. Эрээн булчимнд гич наах, гичтэй халуун бүлээн усанд хөлийг дүрэх

/7./ Залгиурын үрэвслийн үед илрэх эмнэлзүйн шинжүүдийг нэрлэнэ үү.

1. Хоолой аргаж хөндүүрлэх
2. Залгиурын арын хана сэрвэгнэх
3. Ханиалгах, хоолой засах
4. Дуу сөөнгөдүү болох
5. Толгой өвдөх, халуурах, уцаарлах

/8./ Залгиурын стрептококкт үрэвслийн эмчилгээнд тохирохыг зөв сонгоно уу.

1. Антибиотик эмчилгээ
2. Хэсэг газрын эмчилгээ
3. Физик эмчилгээ
4. Бариа засал эмчилгээ
5. Мэс засал эмчилгээ

/9./ Аденоид булчирхайн цочмог үрэвслийн үед илрэх эмнэлзүйн гол шинжүүдийг нэрлэнэ үү?

1. Хамар битүүрч, амаараа амьсгалах
2. Унтахдаа амаа ангайж, хурхирах
3. Нүүр хөөнгөтөн хацрын нугалаас арилах
4. Хоншоор урагш түрсэн байдалтай
5. Амьсгалын замын үрэвсэлт өвчинд өртөмхий

/10./ Хөөмийн гүйлсэн булчирхайн цочмог үрэвслийн эмнэлзүйн шинжүүдээс нэрлэнэ үү.

1. Гүйлсэн булчирхайн салст улайж, үрэвсэх
2. Хонхруудад идээрхэг өнгөр тогтох
3. Өндөр халуурах
4. Шүлс залгих, хоол унд идэж, уухад их өвдөх
5. Зарим үед үе мөчөөр өвдөх

/11./ Дунд чихний цочмог үрэвслийн үед эмнэлзүйд илрэх гол шинжүүдийг нэрлэнэ үү:

1. Халуурч, сульдах
2. Нэг хэсэг хугацаанд тасралтгүй чарлах
3. Унтаж чадахгүй, уйлах
4. Хөхөх үедээ үе үе больж уйлах
5. Хамар битүүрэх

/12./ Гуурсан хоолойн энгийн үрэвслийн үед цээж чагнахад илрэх эмнэлзүйн шинжүүдийг нэрлэнэ үү?

1. Гуурсан хоолойн чимээтэй ширүүн амьсгал
2. Исгэрэх эсвэл олон янзын царгилдсан хуурай хэржигнүүр
3. Заримдаа нойтон хэржигнүүр
4. Шаржигнуур
5. Гялтан шүргэлцэх чимээ

/13./ Хүүхдийн уушгины үрэвслийн зэрэг, хүндрэлтэй байх эсэх нь дараахаас хамааралтай байдаг:

1. Үүсгэгчийн хоруу чанар
2. Эсрэгтөрөгч ба эмгэгтөрөгчийн шинж
3. Хүүхдийн нас
4. Амьдралын нөхцөл
5. Байгал, цаг агаарын нөлөөлөл

/14./ ДЭМБ хүүхдийн уушгины цочмог үрэвслийн оношийн үндэс болох хамгийн чухал шинжид дараахийг оруулжээ:

1. Ханиалгах
2. Амьсгал олшрох
3. Амьсгалд туслах булчин оролцох
4. Цээж хонхолзох
5. Амьсгал саадтай болох

/15./ Уушгины цочмог үрэвсэлтэй хүүхдийн эмчилгээнд дараах орно:

1. Өвчтөнд таатай нөхцөл бүрдүүлэх
2. Шалтгааны эсрэг
3. Эмгэгжамын
4. Амьсгал дутлын эсрэг
5. Дархлааг дэмжих

/16./ Бага эргэлтэнд баяжилттай зүрхний төрөлхийн дараах эмгэгүүд орно.

1. Артерийн битүүрээгүй цорго
2. Тосгуур, ховдол хоорондын таславчийн цоорхой
3. Эйзенменгерийн хамшинж
4. Фаллогийн дөрвөл
5. Эбштейны өвчин

/17./ Ховдол хоорондын таславчийн цоорхойд хамааралтай тодорхойлолтыг зөв сонгоно уу.

1. Зүрхний төрөлхийн гажгуудын дотор хамгийн олонтаа тохиолддог гажгуудын нэг юм
2. Цус эргэлтийн өөрчлөлт нь зүүн ховдлоос баруун руу юүлэгдэнэ.
3. Цус эргэлтийн өөрчлөлт 2-4 сараас эхлэн ажиглагдана
4. Хөхрөх шинж бүхий зүрхний гажгуудаас хамгийн элбэг тохиолддог.
5. Уушгины артерит 1-р авиа өргөгдөж салаална.

/18./ Зүрхний дутагдлын 1-р үед илрэх эмнэлзүйн шинжүүдэд дараах орно:

1. Хөдлөх явах зэрэг ачааллын үед ядрах
2. Тайван үед зүрхний цохилт бага зэрэг олшрох
3. Хөхүүл насны хүүхэд тасалдаж хөхөх
4. Хэвлийн хөндийд шингэн хурах
5. Элэг томрох

/19./ Хэрлэгийн оношлогооны лабораторийн шалгуурт орох үзүүлэлтүүдийг зөв сонгоно уу.

1. Улаан эсийн тунах хурд ихсэх
2. С-урвалжит уураг ихсэх
3. Цагаан эс олшрох
4. Хялгасан судасны бүлэгнэлт ихсэх
5. Зүрхний цахилгаан бичлэгт Т шүд намсах

- /20./ Хэрлэгийн үед бензатинпенициллинG-г тарих зөвлөмжинд дараах орно
1. 27 кг-аас бга жинтэй хүүхдэд 600 000 ед-ээр 21 хоногт 1 удаа
 2. Анхдагч хэрлэг зүрхний үрэвсэлгүй бол 5 жил
 3. 27 кг-аас дээш жинтэй хүүхдэд 1.2 сая ед-ээр 21 хоногт 1 удаа
 4. Анхдагч хэрлэг зүрхний үрэвсэлтэй бол 10 жил
 5. Зүрхний гажиг үүссэн бол 40 нас хүртэл тарих
- /21./ Шенлейн-Генохын өвчин дараах хүчин зүйлээс хамааралтай
1. Өвөл хаврын улирал
 2. Сургуулийн нас
 3. Архаг голомт
 4. Сэргийлэх тарилга
 5. Харшил өгөх хүнсний зүйл
- /22./ Шенлейн-Генохын өвчний үед дараах хэсгээр илүүтэй туурна
1. Үений гадаргуу, ар хэсэг
 2. Хөл гар, өгзөг, бүсэлхий цээж, хүзүү, хааяа нүүр
 3. Шагай шилбэ өгзөг орчим
 4. Тохой мөр шуу
 5. Сарвуу орчим
- /23/ Аль өвчин нь зүрхний дутагдалд хүргэдэггүй вэ?
- A. Хэрэхийн гаралтай хавхлагын гажиг
 - B. Цочмог зүрхний шигдээс
 - C. Геморрагийн шок
 - D. Цочмог миокардит
 - E. Артерийн даралт ихсэлт
- /24/ Дараахи факторуудын аль нь баруун ховдолын даралтын хэт ачааллыг үүсгэдэг вэ?
- A. Гурван хавтаст хавхлагын дутагдал
 - B. Уушигны хавхлагын дутагдал
 - C. Хүнд цус багадалт
 - D. Уушигны артерийн даралт ихсэлт
 - E. Венийн цусны буцах урсгал нэмэгдэх
- /25/ 68 настай эрэгтэй, яаралтай тусламжийн тасагт, цээж болон нурууны хүчтэй өвдөлттэйгээр ирсэн. Өвдөлтөө юм урагдаж, тасарч байгаа мэт гэж дүрсэлсэн. Түүний цусны даралт ихэсдэг, өөр өвчнөөр өвдөж байгаагүй. Бодит үзлэгээр аортын дутагдалтай холбоотой диастолын шуугиантай, 2 гарын систолын цусны даралтын хэмжээ ихээхэн ялгаатай. Хамгийн тохирох онош нь:
- A. Уушигны эмболи
 - B. Цочмог зүрхний шигдээс
 - C. Костохондрит
 - D. Перикардит
 - E. Гол судасны хуулралт
- /26/ Зүүн зүрхний дутагдалын үеийн уушигны зогшингошилын онцлог нь юу вэ?
- A. 2 уушгинд тархмал хуурай, нойтон хэржигнүүр сонсогдоно
 - B. нойтон хэржигнүүр, исгэрэлтгүй
 - C. Хязгаарлагдмал шинжтэй, хэсэг газар тогтсон нойтон хэржигнүүр
 - D. 2 уушгинд тархмал нойтон хэржигнүүр сонсогдоно
 - E. 2 уушгины доод хэсэгт нойтон хэржигнүүртэй, биеийн байрлалаар өөрчлөгдөнө
- /27/ Баруун зүрхний дутагдалын болон элэгний циррозыг ялган оношлох гол зүйл нь аль нь вэ?
- A. *гепатоюгулярный рефлекс* илрэх
 - B. Доод мөчний хаван
 - C. Гялтангийн шүүдэсжилт
 - D. Асцит
 - E. гепатомегалия
- /28/ Уушгины цочмог хавангийн шинж тэмдгүүд нь аль нь вэ?

- A. Амьсгаадах, хөхрөх, тайван бус болох
- B. Уушигны артери дээр 2 –р авиа өндөрсөнө
- C. уушигны исгэрсэн авиа
- D. Ягаан өнгийн хөөстэй цэр
- E. Ритм галопа

/29/ Дигиталис эм аль өвчиний үед эсрэг заалттай вэ?

- A. Тэлэгдэлийн кардиомиопати
- B. Гипертрофическая обструктивная кардиомиопатия
- C. Ишемийн кардиомиопати
- D. Цочмог миокардит
- E. Хэрлэгийн гаралтай зүрхний өвчин

/30/ Цочмог зүүн зүрхний дутагдалын шинж тэмдэгийг сайжруулах хамгийн үр дүнтэй эм бол :

- A. Шээс хөөх эм
- B. Дигиталис
- C. кальцийн (Ca) антагонист эм
- D. Бета хориглогч эм
- E. Ангиотензин хувиргагч ферментийг саатуулагч эм

/31/ Зүүн зүрхний дутагдалын хамгийн эрт үед илрэх шинж тэмдэг бол :

- A. Биеийн ачаалалтай хамааралтай амьсгаадалт
- B. шөнийн пароксизмитэй амьсгаадалт
- C. Олигурия
- D. Цустай цэр гарах
- E. Ортопноэ

/32/ Уушигны цочмог хавантай тохиолдолд яаралтай тусламж үзүүлж байх үед алийг хэрэглэх ёсгүй вэ ?

- A. Метопролол
- B. Фуросемид
- C. Морфин
- D. *Нитропруссид натрия*
- E. Хүчилтөрөгч өгөх

/33/ 60 настай эрэгтэй, титмийн цус тасалдах өвчинтэй, бага зэргийн хөдөлгөөн хийхэд л зүрх дэлсэнэ, амьсгаадана гэсэн зовиуртай. Клиникийн энэ илрэлээр нь зүрхний үйл ажилгааны ангилалын аль шатанд багтах вэ?

- A. зүрхний үйл ажиллагааны I зэрэг
- B. зүрхний үйл ажиллагааны II зэрэг
- C. зүрхний үйл ажиллагааны III зэрэг
- D. зүрхний үйл ажиллагааны IV зэрэг
- E. *Киллипийн ангилалын I-р шат*

/34/ 80 настай эмэгтэй, 2 долоо хоногийн турш гэдэс гүйлгэсний дараа зүрх нь дэлсэж эмнэлэгт хэвтсэн, зүрхний цахилгаан бичлэгт үе үе давтагдсан ховдолын экстрасистоли илэрсэн. Дараахи шалтгаануудын аль нь хэм алдагдалд хүргэсэн байж болох вэ?

- A. Гипонатриеми
- B. Гипокалиеми
- C. Гипокальциеми
- D. Гипомагниеми
- E. Гипопротеинемия

/35/ 35 настай зүрхний хэм алдагдалтай өвчтөн, зүрхний цохилтын тоо минутанд 150, зүрхний хэмнэл жигд, каротид артерт массаж хийсний дараа зүрхний цохилтын тоо минутанд 75 болсон, хэм жигд. Уг өвчтөний онош бол :

- A. Синусын тахикарди

- В. Тосгуурын тахикарди
- С. Тосгуурын трепетани
- Д. Суправентрикуляр тахикарди
- Е. Ховдолын тахикарди

/36/ 45 настай эрэгтэй, даралт ихдэх өвчтэй. 2 өдөр пароксизмал тахикарди өгсөн. Бодит үзлэгээр АД 120/70 mmHg, зүрхний цохилтын тоо минутанд 180 удаа, хэм жигд, зүрхний авиа хэвийн, шуугиангүй. 1 минутын дараа зүрхний цохилтын тоо 80 болж буурсан боловч 30 секундын дараа зүрхний цохилтын тоо дахин минутанд 180 удаа болж ихэссэн. Тохирох онош бол :

- А. Синусын тахикарди
- В. Пароксизмаль тосгуурын фибрилляци
- С. пароксизмаль суправентрикуляр тахикарди
- Д. Пароксизмаль тосгуурын трепетани
- Е. пароксизмаль ховдолын тахикарди

/37/ 65 настай эрэгтэй, сүүлийн 10 жил даралт ихсэж байгаа, тулай өвчтэй. 2 өдөр пароксизмал тахикарди өгсөн. Бодит үзлэгээр АД 180/100 mmHg, уушиг чагналтаар цулцангийн амьсгалтай. зүрхний цохилтын тоо минутанд 50 удаа, хэм жигд, зүрхний авиа хэвийн, шуугиангүй. Лаборторын шинжилгээнд цусан дахи Креатинин 320 мкмоль/л. Энэ өвчтөнд хамгийн тохиромжтой артерийн даралт бууруулах эм аль нь вэ? (Г)

- А. ангиотензин хувиргагч ферментийг саатуулагч
- В. тиазидын шээс хөөх эм
- С. ангиотензины рецепторийг саатуулагч
- Д. кальцийн (Ca) антагонист
- Е. Бета - хориглогч

/38/ 85 настай эмэгтэй, сүүлийн 5 жил даралт ихсэж байгаа, даралтын эм уудаг, АД 140 ~ 170/50 ~ 80 mmHg байдаг. Чихэрийн шижинтэй. Энэ өвчтөний систолийн артерийн даралтыг -г хэдээс доош буулгах хэрэгтэй вэ?

- А. 140 mmHg
- В. 130 mmHg
- С. 125 mmHg
- Д. 120 mmHg
- Е. 110 mmHg

/39/ 61 настай эрэгтэй, артерийн даралт ихсэх өвчтэй. 2-р хэлбэрийн чихэрийн шижинтэй. Шээсэн дэх уураг (+). Энэ өвчтөнд тохирох даралтын эмийг сонгоно уу? (В)

- А. Шээс хөөх эм
- В. кальцийн (Ca) антагонист
- С. ангиотензин хувиргагч ферментийг саатуулагч
- Д. Альфа-блокатор
- Е. бета- хориглогч

/40/ Өвчтөн, эрэгтэй, 25 настай, 2 жилийн турш гематури, протеури илрээсэн. Бодит үзлэгээр АД 150/90 mmHg, доод мөчний хавангүй. Лабораторийн шинжилгээ: шээсэнд уураг 0.5 ~ 0.8 г / дл, шээсэнд улаан эс 5 ~ 10 / hr, цусан дахь Cr 125 мкмоль /л, цусан дахь холестерин хэмжээ 6.0 ммоль / л. Хэт авиан шинжилгээгээр 2 бөөний хэмжээ хэвийн. Энэ өвчтөнд хамгийн магадлал өндөр клиник онош нь:

- А. Нефротик хам шинж
- В. шинж тэмдэггүй протеинури ба гематурийн хам шинж
- С. Гипертензийн нефропати

- D. архаг гломерулонефрит
- E. цочмог гломерулонефрит

/41/ Артерийн гипертензитай өвчтөн, цусны даралт нь 220/120 ммHg. Амьсгалахад хэцүү, хэвтэж болохгүй байна гэсэн зовиуртай. Үзлэгээр 2 уушиганд тархмал нойтон хэржигнүүртэй. Эмчилгээнд аль судас өргөсгөх эмийг сонгох хэрэгтэй вэ?

- A. Бензол оксазолин
- B. каптоприл
- C. нитропруссид натри
- D. нитроглицерин
- E. Нифедипин

/42/ Эрэгтэй, 40 настай. Үе үе гэнэт зүрх дэлсэж, толгой өвдөн их хөлөрнө, тэр үедээ цусны даралт 230/130 ммМУБ хүрдэг, бусад үед цусны даралт их биш. Өвчнийг оношилоход туслах хамгийн оновчтой арга бол даралт өндөрсөж хямрах үед шээсэнд дараахи бодисуудын алийг тодорхойлох нь чухал вэ?

- A. Катехоламин
- B. уураг
- C. кали, натри, хлор
- D. кальци, фосфор
- E. чөлөөт кортизол

/43/ Эрэгтэй, 32 настай, цусны даралтыг ихсээд 3 жил болж байгаа. Өнгөрсөн 1 жилийн хугацаанд цусны даралт байнга 170-200 / 130-140 ммHg байх болсон. Сүүлийн 1 долоо хоног толгой нь өвдөж, нүдний хараа нь муудсан. Нүдний угийн шинжилгээнд харааны мэдрэлийн дискийн хаван илэрсэн. Энэ хүний онош нь :

- A. Цочмог харааны мэдрэлийн эмгэг
- B. тархинд цус харвах
- C. Хоруу явцтай артерийн даралт ихсэлт
- D. тархины шигдээс
- E. гипертензийн энефалопати

/44/ Тогтвортой стенокарди

- A. Сүүлийн 3 сарын хугацаанд ачаалалаас үүдэлтэй стенокардын давтамж болон өвдөлтийн хүч, нитроглицериний хэрэгцээ нэмэгдэж байгаа.
- B. Стенокардийн хөдлөл нь биеийн хөдөлгөөнтэй ямар ч холбоогүй бөгөөд ST сегментийн түр зуурын өндөрсөлт илэрнэ.
- C. Стенокардийн хөдлөл нь биеийн хөдөлгөөнтэй холбоотой бөгөөд түүний шинж чанар нь 3 сарын дотор өөрчлөгдөхгүй.
- D. стенокарди болон миокардийн шигдээсийн түүхгүй боловч, сүүлийн 1-2 сарын дотор ачаалалаас үүдэлтэй үүсэж байгаа стенокарди
- E. Ядарсан болон амарч байх үед илэрч байгаа стенокарди

/45/ Эрэгтэй, 68 настай. 1 долоо хоногийн өмнө өглөө анх дасгал хийсний дараа цээжээр нь өвдөж, өвдөлт нь 10 орчим минут үргэлжилж, тайван амарсаны дараа намдсан. 1 жилийн өмнө бие махбодийн үзлэгээр *Glycated haemoglobin (HbA1c)* 8.3% байсан ба өөр эмгэг илрээгүй. Цээжний өвдөлт өгч байх үеийн зүрхний бичлэгт V1-V6 холболтонд ST-гийн буулт илэрсэн. Энэ өвчтөний цээжний өвдөлтийг үүсгэж байгаа өвчин бол :

- A. Стенокарди
- B. Костохондрит
- C. Гипертрофийн кардиомиопати
- D. Зүрхний шигдээс
- E. уушигны тромбозболи

/46/ 30 настай, эмэгтэй, 4 мөч сул, шөнө олон шээдэг болоод 3 жил болж байгаа.

Сүүлийн 3 хоног 2 хөл нь хөдөлхөө больсон. Үзлэгээр АД 175/110 mmHg, цусны кали 2.2 ммоль/л. Энэ хүний онош нь :

- A. Феохромоцитома
- B. Анхдагч альдостеронизм
- C. Аортын коарктация
- D. Бөөрний артерийн атеросклероз
- E. Кушингийн хам шинж

/47/ 30 настай, эмэгтэй, дээд мөчний АД 190/110 mmHg, доод мөчний АД 145/90 mmHg, бодит үзлэгээр ;далны орчим судасны шуугиан сонсогдож, чичиргээ мэдрэгдэнэ. Нэмэлт шинжилгээ :шээсэнд дэх 17 ketone, 17-hydroxy aldosterone болон

Vanillylmandelic Acid - ийн хэмжээ хэвийн. Энэ хүний онош нь :

- A. Феохромоцитома
- B. Анхдагч альдостеронизм
- C. Бөөрний артерийн нарийсал
- D. Кушингийн хам шинж
- E. Аортын коарктация

/48/ Баруун тал бөмбөлгийн хамшинж

1. анозогнози
2. аутопогнози
3. биеийн бүдүүвч өөрчлөгдөх
4. псевдомиели
5. сенсор афази

/49/. Эмгэг хөдөлгөөний хэлбэрүүд

1. брэфароспазм
2. тик
3. хороя
4. баллизм
5. дистони

/50/. Булчингийн даамжрах хатингарлын шинж тэмдгүүд

1. Нугасны явдал
2. Булчингийн хуурамч бүдүүрэл
3. Шаталж өндийж босох
4. Далны ёрдойх хамшинж
5. Булчингийн проксимал хатангирал

/51/. Эмгэг хөдөлгөөний биохимийн үндэс

1. ацетилхолин ихсэнэ
2. дофамин ихсэнэ
3. дофамин буурна
4. ацетилхолин буурна
5. серотонин буурна

/52/. Паркинсонизмын хамшинжээр илрэх өвчнүүд

1. гепато-церебральная дистрофия
2. судасны паркинсонизм
3. паркинсоны өвчин
4. дистони
5. тахалт энцефалит

/53/. Паркинсонизмын биохимийн өөрчлөлт

1. дофамины түвшин ихсэнэ
 2. дофамины түвшин буурна
 3. ацетилхолины хэмжээ буурна
 4. ацетилхолины хэмжээ ихсэнэ
 5. серотонин ихэснэ
- /54/. Паркинсонизмын эмгэг морфологи

1. тархины эдийн гэмтэл
 2. жижиг цус харвалт
 3. тархины бүрхүүл зузаарах
 4. хар биеийн дегенераци
 5. миелин бүрхүүлийн задрал
- /55/. Паркинсонизмын эмчилгээ

1. L-DOPA агуулсан бэлдмэл
 2. холинолитик
 3. эмчилгээний дасгал
 4. бүлэгнэлтийн эсрэг бэлдмэл
 5. агрегаци эсрэг
- /56/. Нугасны гаднаас дарсан хавдрын үе шатууд

1. ёзоор дарагдах
 2. Броун-Секарын хамшинж
 3. нугасны хөндлөн огтлолын гэмтэл
 4. нугасны үрд эврийн дарагдал
 5. мэдрэхүй өгсөж алдагдах
- /57/. 60 настай эрэгтэй, өглөө унтаад сэрэхэд баруун гар, хөл саажиж, хэл яриагүй болсон. Нэн шаардлагатай шинжилгээнүүд.

1. тархины судасны доплерографи
 2. ЭКГ
 3. коагулографи
 4. тархины КТ
 5. тархины цахилгаан бичлэг
- /58/. Меньер шинжийн эмнэл зүй:

1. толгой эргэх
 2. бөөлжилт
 3. чих шүүгих
 4. тэнцвэргүйдэл
 5. хэл дультрах
- /59/. Экстрапирамид тогтолцооны бүрэлдэхүүн

1. сүүлт бөөм
 2. хар биет
 3. улаан бөөм
 4. люисын бөөм
 5. цац бөөм
- /60/. Нүд хөдөлгөгч мэдрэлүүдийн зам бүтэц.

1. Даркшевичийн бөөм
2. Цилиар зангилаа
3. Якубович бөөм
4. Хоёр туйлт эсүүд
5. Голлийн зам

/61/. Их калийт үечилсэн саажлын сэдрэл ямар нөхцөлд тохиолдох вэ?

1. Хүнд ажлын үед
2. хүнд ажлын дараа
3. Шөнө нойрон дунд
4. Өдөр амарч байх үед
5. Дээрхи нөхцлүүдийн алинд ч үүснэ

/62/. Тархины баруун дунд артерийн бөглөрлийн шинжийг нэрлэнэ үү:

1. Зүүн талын тал хараагүйдэл
2. Зүүн талын талласан саа
3. Анозогнози
4. псевдомиели
5. сенсор афази

/63/. 30 настай эмэгтэйн 2 хөл өвдөнө, булчингууд хатингар, тавхайн хэлбэр өөрчлөгдсөн өлмийдөж гишгэнэ. Ул, борви, өвдөгний рефлексүүд арилсан. Өвдөгнөөс доош өнгөц мэдэрхүй буурсан. Аарцагний үйл алдагдаагүй.

1. Доод мөчний захын саа
2. Булчингийн даамжрах хатингирал
3. Адуун сүүлийн хамшинж
4. Полиневропатийн шинж
5. Полиомиелит

/64/Тархины эзэлхүүнт эмгэгийн онцлог шинж:

1. Гавлын дотоод даралт даамжран нэмэгдэх
2. Тархины голомтот шинж илрэх
3. Тархины ерөнхий шинж
4. 2 талд эмгэг рефлекс илрэх
5. шөнөдөө халуурах

/65/ Гийен-Баррын өвчний онцлог шинж :

1. Мөчдийн угаар давамгай сул саа
2. Мэдэрхүй захын хэв шинжээр буурах
3. Амьсгалын дутагдал
4. Тархи-нугасны шингэнд уураг-эсийн зөрүү
5. Тархи-нугасны шингэнд эс-уургийн зөрүү

/66/ Миастени кризын эмнэл зүй :

1. Булчин сулрал даамжрах
2. Залгилт буурах
3. Амьсгалын дутагдал
4. Шүлс их ялгарах,
5. Брадикарди

/67/ Тархины баганы цус харвалтын эмнэл зүй:

1. Гавал тархины мэдрэлийн саа
2. Хүүхэн хараа ижил бус болох
3. Пирамид замын гэмтлийн шинж
4. Тархины бүрхүүл цочролын шинж
5. чангарсан таталт

/68/ Бага тархины цус харвалтын эмнэл зүй:

1. Бөөлжих
2. Динамик атакси
3. Нүд хөдөлгөгч мэдрүүлийн саа

4. Астази-абази
5. сенситив атакси

/69/ Өвчтөний зүүн нүд нь хатгаж өвдөнө, духаар цэврүүтэй тууралт гарч, нүднээс их хэмжээгээр нулимс гоожсон. Өвчин намдаах эмэнд үр дүнгүй. Духны зүүн талд өвдөлтийн гиперстезитэй, эвэрлэгийн рефлекс арилсан. Таны онош, авах арга хэмжээ.

1. Ацикловир хэрэглэх
 2. Гассер зангилааны ганглионит
 3. Карбамазепин хэрэглэх
 4. Гурвалсан мэдрэлийн ян
 5. Өвчин намдаах хориг
- /70/. Явдал өөрчлөгдөх өвчнүүд

1. Хэвийн даралтат гидроцефали
2. Паркинсоны өвчин
3. Шарко-Мари өвчин
4. Гүүр-бага тархины сөнөрөл
5. супрануклеар саажил

/71/ Тархмал хатуурлын оношлогоонд шаардлагатай шинжилгээ:

1. Тархины МРТ
2. Нугасны усанд IgG олигклонал банд
3. Харааны мэдрэлийн дуудлагат потенциал
4. Нойрны тархины цахилгаан бичлэг
5. доплерсонографи

/72/. Нойрны өөрчлөлтөөр илэрдэг өвчнүүд.

1. Тахалт энцефалит
2. Пикийн өвчин
3. Нарколепси
4. Леви биет сөнөрөл
5. Кожевниковын эпилепси

/73/. Аль нь ерөнхий уналт таталтанд орох вэ?

1. Вестын хамшинж
2. Идэр насны миоклоник эпилепси
3. Атоник таталт
4. Абсанс
5. Леннокс Гасто хам шинж

/74/ Эпилепсийн статусын үед авах арга хэмжээ.

1. Диазепам 20 мг судсаар тарих
2. Тиопентал 50 мг дуулаар хийх
3. Мидазолам тарих
4. Булчин сүлрүүлэх унтуулга
5. Лоразепам 4 мг судсаар тарих

/75/ Таталтын эсрэг бэлдмэлийн гаж нөлөө.

1. Ургийн гаж хөгжил
2. Трмбоцитопени
3. Элгэнд нөлөөтэй
4. Зүрхний шигдээсд хүргэнэ
5. ходоодны шархлаа үүсгэнэ

/76/ Жолооч мэргэжилтэй өвчтөний баруун тохойгоор өвдөж гарын 4,5 хуруунууд бадайрч, сарвууны хүч буурсан.

1. Дунд мэдрэлийн дарагдал
2. Тохойн сүвгийн хамшинж

3. Сарвууны сүвгийн хамшинж
4. Тохойн мэдрэл хавчигдал
5. шууны мэдрэл хавчигдал

/77/ Перинаталь гэдэг ойлголтонд хамаарахыг нэрлэнэ үү?

- A. Жирэмсний эхний 20 долоо хоног хүртлэх хугацаа
- B. Үр хөврөл бүрэлдэн тогтсоноос төрөх хүртлэх хугацаа
- C. Жирэмсний 22 долоо хоногтойгоос төрөх хүртлэх хугацаа
- D. Жирэмсний 22 долоо хоногоос төрсний дараах эхний 168 цаг хүртлэх хугацаа
- E. Жирэмсний 28 долоо хоногтойгоос төрсний дараа 7 өдөр хүртлэх хугацаа

/78/ Ургийн зүрхний цохилтыг чагнах үйлдлийн зөвийг нэрлэнэ үү:

- A. Жирэмсний 12 долоо хоногтойгоос чагнана
- B. Төрөлтийн 1- үед цаг тутамд чагнана
- C. Стетоскопоор чагнахдаа 30 секундын турш тасралтгүй чагнана
- D. Жирэмсний сүүлийн долоо хоногт 24 цагт нэг удаа
- E. Дүлэлт болгоны дараа чагнана

/79/ Дараах байдлуудын алийг нь төрөлт эхэлсэн гэж тооцох вэ?

- A. Ургийн шингэн гарснаар
- B. Ургийн толгой доошилсноор
- C. Умайн хүзүү бэлтгэгдснээр
- D. 10 хормын зайтай жигд базалж эхэлснээр
- E. Умайн ёроол доошилж амьсгал авахад чөлөөтэй болсноор

/80/ Эргэлдэх цусны хэдэн хувь хүртэл алдахад эхэд дасан зохицолтой байх вэ?

- A. 5%
- B. 8%
- C. 10%
- D. 12%
- E. 15%

/81/ Аль нь умайн хамааралтай биений юмгүйдлийг илэрхийлэх вэ?

- A. Хэт авиан шинжилгээнд умайн салст зузаарсан
- B. ФСГ болон ЛГ ихэссэн
- C. Хэт таргалалттай
- D. Прогестероны сорил сөрөг
- E. Умайн хэмжээ томорсон

/82/ Жирэмсний 20 долоо хоногтойд ургийн урт ойролцоогоор хэдэн см байх вэ ?

- A. 10-12 см
- B. 13-15 см
- C. 16-20 см
- D. 21-25 см
- E. 26-28 см

/83/ Жирэмсний эрт хугацаанд хамгийн элбэг тохиолддог хүндрэлийг нэрлэнэ үү:

1. Жирэмсний сөөргөө

2. Эрт үеийн хордлого
3. Цус багадалт
4. Даралт багасах
5. Цистит

/84/ Ургийн нуруулалт гэдэг нь:

- A. Ургийн нуруу эхийн хажуу ханатай харьцаж байрласан
- B. Ургийн нуруу эхийн урд ханатай харьцаж байрласан
- C. Ургийн нуруу ард ханатай харьцаж байрласан
- D. Ургийн нуруу эхийн умайн дагуу тэнхлэгт харьцаж байрласан
- E. Ургийн нуруу умайтай дагуу тэнхлэгтэй хурц өнцөг үүсгэж байрласан

/85/ Төрсний дараах үе гэдэгт аль хугацааг хамааруулж үзэх вэ?

- A. Төрсний дараах эхний 24 цаг
- B. Төрсний дараа эхний 2 цагаас 4 долоо хоног хүртэл
- C. Төрснөөс хойш 4-6 долоо хоног
- D. Төрснөөс хойш 6-8 долоо хоног
- E. Төрснөөс хойш 3 сар

/86/ Жирэмсний хэдэн долоо хоногтойгоос эхлэн ургийн кардиотокографийн бичлэг хийх нь тохиромжтой вэ?

- A. Жирэмсний 22 долоо хоногтойгоос
- B. Жирэмсний 28 долоо хоногтойгоос
- C. Жирэмсний 32 долоо хоногтойгоос
- D. Жирэмсний 36 долоо хоногтойгоос
- E. Жирэмсний 38 долоо хоногтойгоос

/87/ Төрсний дараа цус алдаж байгаа үед эхийн судсанд ямар хэмжээтэй уян зүү тавих вэ?

- A. Хэмжээ хамаарахгүй
- B. 16-18G
- C. 18-20G
- D. 20-22G
- E. 24-26G

/88/ Жирэмсэн шинж тэмдэггүй бактериури гэдэгт 1 мл шээсэнд нянгийн хэмжээ хэд болохыг хэлэх вэ?

- A. 20,000
- B. >30,000
- C. >80,000
- D. >100,000
- E. . >120,000

/89/ Шээсний шинжилгээнд уураг хэдэн г/л байхыг хэвийн гэж үзэх вэ?

- A. Уураг илрэх ёсгүй
- B. 0,033 г/л

- C. 0,040 г/л
- D. 0,045 г/л
- E. 0,050 г/л

/90/ Хэвийн явцтай жирэмсэн эмэгтэйд хэдэн долоо хоногтойд нян өсгөвөрлөх шинжилгээг хийх ёстой вэ?

- A. 8-12 долоо хоногтой
- B. 12-16 долоо хоногтой
- C. 18-22 долоо хоногтой
- D. 23-27 долоо хоногтой
- E. >28 долоо хоногтой

/91/ Жирэмсэн эмэгтэйн өглөө өлөн үед цусанд сахар хэд байвал хэвийн гэж үзэх вэ?

- A. 2,5-3,5
- B. 4,5-5,5
- C. 6,0-7,0
- D. 7,1-7,5
- E. 7,6-8,0

/92/ Билирубиний хэмжээ хэдээс дээш байхад арьсанд шарлалт үүсдэг вэ?

- A. >6,8 ммоль/л
- B. >13 ммоль/л
- C. >18 ммоль/л
- D. >20 ммоль/л
- E. >35 ммоль/л

/93/ В вирусын халдвараас сэргийлэх вакцин төрсний дараа хэзээ хийх ёстой вэ?

- A. Дөнгөж төрмөгц төрөх өрөөнд
- B. 12-24 цагийн дотор
- C. 24-48 цагийн дотор
- D. 48-72 цагт
- E. Сарын дараа

/94/ Нярайд С вирус дамжсан эсэхийг хэдэн сарын дараа шалгах боломжтой гэж эхэд зөвлөх вэ?

- A. Төрсний дараа 24 цагт
- B. 7хоногийн дараа
- C. 1-3 сарын дараа
- D. 4-6 сарын дараа
- E. 12-18 сарын дараа

/95/ Жирэмсэн үед 24 цагийн шээсэнд уургийн хэмжээ хэдэн мг бол манас таталтын урьдлын хөнгөн зэрэг гэж үзэх вэ?

- A. 100 мг/хоногт
- B. 150 мг/хоногт

- C. 200 мг/хоногт
- D. 250 мг/хоногт
- E. 300 мг/хоногт

/96/ Сүрьеэгийн каверныг уушгины буглаанаас ялгах шинжийг тодорхойлно уу:

- A. Хөндий цацагдсан голомтуудын хамт
- B. Гөлгөр ханатай, шингэний түвшинтэй хөндий
- C. Цустай цэр гарна
- D. Хордлогын шинж
- E. Эритроцитын тунах хурд ихсэх

/97/ БЦЖ вакциныг

- A. Арьсан дор тарина
- B. Арьсанд тарина
- C. Булчинд тарина
- D. Уулгана
- E. Хамарт дусаана

/98/ Уушгины том хэмжээний нээгдсэн буглааны үед дараахаас бусад шинжүүд гарна:

- A. Цэрний хэмжээ ихсэх
- B. Хордлогын шинжүүд багасах
- C. Голомтонд тогшилтын дуу богиносч, амьсгал суларсан
- D. Голомтонд тогшилтоор хэнгэргэн дуутай, гуурсан хоолойн эсвэл амфорын амьсгалтай
- E. Биеийн халуун буурах

/99/ Уушгины архаг бөглөрөлт өвчинд тохирохгүй тодорхойлолтыг сонгоно уу

A. Агаар дамжилтын алдагдал агаарын жижиг замын өвчин ба паренхимийн деструкцийн шалтгаантай байдаг

B. Агаар дамжилт алдагдсан уушгины архаг бөглөрөлт өвчтэй хүнд ханиах, цэр гарах, амьсгаадах шинж илэрнэ

C. Архаг үрэвсэл бүтцийн алдагдал ба гуурсан хоолойн нарийсал үүсгэдэг

D. Уушгины паренхимийн деструкци амьсгал гаргах үед амьсгалын зам нээлттэй байх чадварыг бууруулдаг

E. Уушгины архаг бөглөрөлт өвчний үеийн агаар дамжилтын саатал ихэвчлэн даамжрах хандлагатай байдаг

/100/ Ортопноэ:

- A. Баруун ховдлын хурц дутагдлын үед илэрнэ
- B. Баруун ховдлын архаг дутагдлын үед илэрнэ
- C. Зүүн ховдлын дутагдлын үед илэрнэ
- D. Баруун, зүүн ховдлын дутагдлын аль алиных нь үед илэрнэ
- E. Амьсгалын дутагдлын үед илэрнэ